

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: **Эрүүл мэндийг дэмжих төвүүдэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж** нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
Тендер шалгаруулалтын дугаар: ЭМХТ-20201106/04

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **"Эрүүл мэндийг дэмжих төвүүдэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендер"**-т үнийн санал цахимаар ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000 (тавин мянга) төгрөгийг ЭМХТ, Төрийн сан банк 100900020405 тоот данс /РД:9086331/-д төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер шалгаруулалт дараах багцуудаас бүрдэнэ.

Багц 1. Ачаалалтай зүрхний цахилгаан бичлэгийн аппарат

Багц 2. Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат

Багц 3. Холтер /бичигчтэй/

Багц 4. Нүдний хараа шалгах таблиц

Багц 5. Слит ламп /биомикроскоп/

Багц 6. Авторефракто/кератометр

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. **Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:** 2018, 2019 болон 2020 оны эхний хагас жилд тухайн тендерт санал болгож буй багцийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй барааг нэг удаагийн гэрээгээр нийлүүлсэн байх бөгөөд гэрээ, хүлээлгэн өгсөн акт, захиалагч байгууллагын тодорхойлолтын хамт ирүүлнэ.
2. **Борлуулалтын хэмжээ:** 2018, 2019 болон 2020 оны эхний хагас жилийн дундаж борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
3. **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх бөгөөд харилцагч банкны дансны үлдэгдлийн тодорхойлолт, шугаман зээлийн эрхийн үлдэгдлийн тодорхойлолтоор тооцно.
4. **Төсөвт өртгийн 1% -тай тэнцэх тендерийн баталгаа ирүүлнэ.**

Багцын нэр	Баталгааны дүн /төг/
Багц 1. Ачаалалтай зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	1,400,000.0
Багц 2. Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	500,000.0
Багц 3. Холтер /бичигчтэй/	1,400,000.0
Багц 4. Нүдний хараа шалгах таблиц	1,250,000.0
Багц 5. Слит ламп /биомикроскоп/	1,900,000.0
Багц 6. Авторефракто/кератометр	1,900,000.0

Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: 2020 оны 11 дүгээр сарын 13 -ны өдрийн 14.00 цагаас өмнө үнийн саналыг ирүүлнэ.

Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 14 цаг 30 минут. Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 3 давхрын хурлын танхимд нээнэ.

Эрүүл мэндийн хөгжлийн төв, Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Энхтайвны гудамж-13Б, Монгол Улс, Улаанбаатар хот-210648, Ш/Х-187,

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 203 тоот,

Харилцах утас: /70128805/